



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 774

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны онцлогийг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Д.Жавхланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4.Арга хэмжээний биелэлтийн хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003150

32-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
774 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДОТООД АЛБАН
ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

№	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин /туулах чадвар сайтай/	1
2		Хот, доторх ажлын суудлын автомашин /жижиг/	2
Нийт автомашин			3